



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2023 оны 09 сарын 29 өдөр

Дугаар 4/350

Улаанбаатар хот

Г
Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний
аргачлал шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл ахуйн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ хийх аргачлалыг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү тушаалын хэрэгжилтийг мэргэжлийн арга зүйн удирдлагаар хангаж, үнэлгээний аргачлалын сургалтыг зохион байгуулахыг Нийтийн эрүүл мэндийн газар /Д.Баярболд/, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв /С.Өнөрсайхан/-д тус тус даалгасугай.
3. Нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд хийгдэж байгаа эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээнд уг аргачлалыг ашиглах, хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга наарт үүрэг болгосугай.
4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2014 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн А/413 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

САЙД С.ЧИНЗОРИГ

Эрүүл мэндийн сайдын
2023 оны 09 дугаар сарын 09 өдрийн
1/30 дугаар тушаалын хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ

НЭГ. НИЙТЛЭГ ЗҮЙЛ

1. Эрүүл ахуйн тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасны дагуу үйлдвэр, үйлчилгээ, барилга байгууламжийг барих, шинэчлэх, өргөтгөх аливаа бодлого, хөтөлбөр, төслийн үйл ажиллагаанаас оршин суугчдын эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг тодорхойлж, төслийг хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөлгүйгээр хэрэгжүүлэхэд чиглэсэн зөвлөмж боловсруулах зорилгоор эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ (цаашид үнэлгээ гэх)-г хийж гүйцэтгэнэ.
2. Энэхүү аргачлалыг үнэлгээ хийж буй хуулийн этгээд, мэргэжлийн баг нь ерөнхий удирдамж байдлаар ашиглах бөгөөд төслийн онцлог, чиглэлд нийцүүлэн нарийвчилсан аргачлалыг боловсруулж, Эрүүл мэндийн сайдын 2023 оны A/142 дугаар тушаалаар баталсан “Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ хийх байгууллагыг сонгон шалгаруулах журам шинэчлэн батлах тухай” журмыг мөрдлөг болгон ажиллана.
3. Үнэлгээг хийх гүйцэтгэгч нь үнэлгээний дүгнэлт, зөвлөмжтэй холбоотой шийдвэрийг хариуцах чадвар бүхий хуулийн этгээд байна.
4. Үнэлгээг хийх багийн гишүүд нь дүгнэлт гаргах, зөвлөгөө өгөх, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилтийн чиглэлээр мэргэшсэн, тухайн салбарт 5-аас доошгүй жил ажилласан туршлагатай байна.

ХОЁР. ҮНДСЭН ЗАРЧИМ

Үнэлгээг хийж гүйцэтгэхэд дараах зарчмыг баримтална. Үүнд:

- 2.1 Олон нийтийн оролцоог дэмжих: Иргэдийн аюулгүй байдал, эрүүл мэнд, эрх ашиг, хөдөлмөр эрхлэлтэд нөлөөлөх аливаа санал, шийдвэрийг гаргах аливаа үйл ажиллагаанд иргэд, олон нийтийг шууд болон шууд бусаар оролцуулж, хурлын тэмдэглэлийг хавсаргах
- 2.2 Тэгш байдлыг хангах: Хүн амын янз бүрийн бүлгүүдийн доторх болон тэдгээрийн хооронд эрүүл мэндийг тодорхойлох хүчин зүйлс ба/эсвэл зайлсхийх боломжтой эрүүл мэндийн ялгаатай байдлыг багасгах, эмзэг бүлгийг анхаарах
- 2.3 Эрүүл мэндийг өргөн хүрээнд авч үзэх: Эрүүл мэндийг зөвхөн өвчлөл, нас баарaltaар хэмжих бус, хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн байдал, амьдарч буй орчин, нөхцөл, өрхийн орлого, боловсролын тувшин зэрэг эрүүл мэндийн тодорхойлогч хүчин зүйлстэй холбон судлах

ГУРАВ. ЭРҮҮЛ МЭНДИЙН НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨРӨЛ

- 3.1 Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээг хийхдээ төслийн үе шатнаас хамаарч дор дурдсан нөлөөллийн үнэлгээний аль нэг төрлийг сонгож хийнэ. Үүнд:

- 3.2 Эрүүл мэндийн нөлөөллийн урьдчилсан үнэлгээ
- 3.3 Эрүүл мэндийн нөлөөллийн суурь үнэлгээ
- 3.4 Эрүүл мэндийн нөлөөллийн явцын үнэлгээ

3.2 Эрүүл мэндийн нөлөөллийн урьдчилсан үнэлгээ

- 3.2.1 Шинээр байгуулах үйлдвэр, үйлчилгээ, уул уурхай, барилга байгууламж, тэдгээрийг шинэчлэх, өргөтгөх, нийтийн эдэлбэр болон гэр хорооллын газрыг дахин төлөвлөж буй төсөлд эрүүл мэндийн нөлөөллийн урьдчилсан үнэлгээ хийнэ. Урьдчилсан үнэлгээг хийхэд төслийн төлөвлөлтийн баримт бичиг, ижил төстэй төсөлд хийсэн эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний тайлан, бусад эх сурвалжаас цуглуулсан, баримт нотолгоог ашиглана.
- 3.2.2 Эрүүл мэндийн нөлөөллийн урьдчилсан үнэлгээгээр тухайн төсөл нь оршин суугчдын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлнэ гэж таамаглан үнэлгээг хийсэн боловч төсөлтэй холбоотой сөрөг нөлөө байхгүй эсвэл аюулгүйн түвшинд хүртэл бууруулах технологи, эдийн засгийн хувьд боломжтой гэсэн дүгнэлт гарсан үед уг төслийг хэрэгжүүлнэ.

3.3 Эрүүл мэндийн нөлөөллийн суурь үнэлгээ

- 3.3.1 Үйлдвэр, үйлчилгээ, уул уурхай, барилга байгууламжийн төслийг хэрэгжүүлж эхэлснээс хойш 12 сарын дотор тухайн төсөлд эрүүл мэндийн нөлөөллийн суурь үнэлгээг хийнэ.
- 3.3.2 Эрүүл мэндийн нөлөөллийн суурь үнэлгээгээр төслийг хэрэгжиж эхлэх үед оршин суугчдын эрүүл мэндийн байдал ямар байсныг тодорхойлно. Түүнчлэн энэхүү үнэлгээгээр төслийн богино хугацааны бодит нөлөөллийг тодорхойлж, сөрөг нөлөөллийг эрт үед нь арилгах, бууруулах арга хэмжээг төлөвлөх ёстой.

3.4 Эрүүл мэндийн нөлөөллийн явцын үнэлгээ

- 3.4.1 Үйлдвэр, үйлчилгээ, уул уурхай, барилга байгууламжийн төслийг хэрэгжүүлж эхэлснээс хойш 5 жилд тутамд эрүүл мэндийн нөлөөллийн явцын үнэлгээ хийж, суурь үнэлгээ хийснээс хойш тухайн төслийн улмаас оршин суугчдын эрүүл мэндэд гарсан сөрөг нөлөөлөл хэрхэн өөрчлөгдж байгааг хянана.

ДӨРӨВ. ЭРҮҮЛ МЭНДИЙН НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ ҮЕ ШАТУУД

Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ нь нөхцөл байдлыг үнэлэх, цар хүрээг тодорхойлох, дүн шинжилгээ хийх, үр дүнгийн менежмент хийх, хэрэгжилтийг хянах үндсэн 5 үе шатнаас бүрдэнэ.

4.1 Нөхцөл байдлыг үнэлэх

- 4.1.1 Үнэлгээ хийх хэрэгцээ шаардлагыг тодорхойлох зорилгоор шийдвэр гаргагчид, төсөл хэрэгжүүлэгчид, олон нийтийн төлөөлөл, эрүүл мэндийн болзошгүй нөлөөллийн талаарх мэдээлэлтэй төлөөллүүдийг хамруулна.
- 4.1.2 Нөхцөл байдлыг үнэлэх үе шатанд төслийн гол үзүүлэлтийг тоймлох, нөхцөл байдлыг үнэлэх, зөвлөмж боловсруулах үйл ажиллагааг хийж гүйцэтгэнэ.

- 4.1.3 Төслийн гол үзүүлэлтийг тоймлоходоо төслийн улмаас эрүүл мэндэд үзүүлэх болзошгүй нөлөөллийг тодорхойлж, цаашид төсөлтэй холбоотой шийдвэр гаргахад анхаарах гол асуудал, үнэлгээнд шаардлагатай нотолгооны бэлэн байдал, санхүүгийн болон хүний нөөцийн хүртээмжтэй байдлыг тодорхойлно.
- 4.1.4 Нөхцөл байдлыг үнэлэхдээ төсөл нь хүн амын эрүүл мэнд, сайн сайхан байдалд шууд болон дам байдлаар хэрхэн нөлөөлөх, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн халамжийн үйлчилгээний эрэлт хэрэгцээ, хүртээмжид өөрчлөлт орох эсэхийг харгалzan тооцоолно.
- 4.1.5 Зөвлөмж боловсруулах ажлын хүрээнд үнэлгээ хийх шаардлагатай эсвэл шаардлагагүй гэдгийг тодорхойлж, болзошгүй нөлөөллийг багасгах талаарх мэдээллийг тусгана.
- 4.1.6 Нөхцөл байдлыг үнэлэх үе шатны тайланд гаргасан шийдвэр, зөвлөмжийн үндэслэл, төслийн товч танилцуулга, эрүүл мэндэд үзүүлэх болзошгүй нөлөөллийн танилцуулга, эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ хийх боломжит нөөцийн шаардлага зэргийг багтаана.

4.2 Цар хүрээг тодорхойлох

Энэ үе шатанд нөлөөлөлд өртөж болзошгүй хүн ам, үнэлгээнд ашиглах аргууд, зөвлөлдөх, хамтран ажиллах техникийн мэргэжилтнүүд болон оролцогч талуудын хүрээ зэргийг тодорхойлдог ба дараах үйл ажиллагааг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

- 4.2.1 Үнэлгээний багийн ахлагч нь гишүүдийн ажил, үүргийн тодорхойлолтыг тэдгээрийн санал, оролцоонд тулгуурлан боловсруулж, үнэлгээний цар хүрээг тодорхойлно.
- 4.2.2 Төслийн онцлогоос хамаарч үнэлгээний бүрэлдэхүүнд тухайн чиглэлийн мэргэжлийн шинжээч, төрийн болон төрийн бус байгууллагын холбогдох мэргэжилтэн, орон нутгийн иргэдийн төлөөллийг нэмэлтээр оролцуулж болно.
- 4.2.3 Үнэлгээ хийх газар зүйн байршил болон хугацааг төлөвлөн тооцоолно. Зарим нөлөөлөл нь хүн амын эрүүл мэндэд шууд бусаар нөлөөлдөг байдлыг харгалzan газар зүйн байршлыг нарийвчлан тодорхойлно.
- 4.2.4 Үнэлгээний баг нь хүснэгт 1-ийг ашиглан тухайн төслийг хэрэгжүүлэх явцад эрүүл мэндийн болзошгүй сөрөг нөлөөлөлд өртөх магадлалтай хүн амын эмзэг бүлгийг тодорхойлно.

Хүснэгт 1. Нөлөөлөлд өртөж болзошгүй эмзэг бүлгүүдийн ангилал

Хүйстэй холбоотой бүлэг	Настай холбоотой бүлэг	Ялгаварлан гадуурхалтад өртөх эрсдэл ба нийгмийн бусад сул талууд	Орлоготой холбоотой бүлэг	Газар зүйн байршил/ нөхцөл байдал
Эрэгтэй Эмэгтэй Бусад	Хүүхэд, залуучууд Жирэмсэн, хөхүүл эмэгтэй Насанд хүргчид Өндөр настан Оюутан, сурагчид	Яс үндэс Шашин, хэл, соёлын ялгаатай хүмүүс Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс Өрх толгойлсон эцэг, эх Архаг өвчтэй хүмүүс Сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүс Асрамжийн газрын хүмүүс Орон байргүй хүмүүс Бэлгийн чиг хандлага өөр хүмүүс	Бага орлоготой хүмүүс Хөдөлмөрийн чадвараа алдсан хүмүүс Ажил, орлогогүй хүмүүс	Төслийн ойр орчинд байгаа хүмүүс: ажлын байр/сургууль/эмнэлэг/ асрамжийн газар/гэр Эдийн засгийн хөгжил муу бүс нутаг Эрүүл мэндийн үзүүлэлт муу бүс нутаг Алслагдсан орон нутаг эсвэл хүн амын төвлөрөл ихтэй бүс нутаг

4.2.5 Эмзэг бүлгийн хүн амд үзүүлэх эерэг, сөрөг нөлөөлөл, эрүүл мэндэд нөлөөлөх замыг хүснэгт 2-ыг ашиглан тодорхойлно.

Хүснэгт 2. Нөлөөлөлд өртөж болзошгүй хүн амын эмзэг бүлэг, нөлөөлөх замыг тогтоох

Эмзэг бүлэг	Эрүүл мэндийн нөлөөлөл		Эрүүл мэндэд нөлөөлөх зам	
	эерэг	сөрөг	шууд	шууд бүс
Хүйс				
Насны бүлэг				
Ялгаварлан гадуурхалтад өртөх магадлалтай бүлэг				
Орлоготой холбоотой бүлэг				
Газар зүйн байдал ба бусад нөхцөл байдал				

4.2.6 Үнэлгээний түвшинг сонгоходоо үнэлгээний багийн нөөц, хүчин чадал, төслийн хэмжигдэхүүн, болзошгүй нөлөөллийн хэмжээ зэргийг харгалзан баримтад суурилсан, түргэвчилсэн, завсрын болон цогц үнэлгээний аль нэгийг ашиглана.

Хүснэгт 3. Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний түвшин

Баримтад суурилсан	Түргэвчилсэн	Завсрын	Цогц
2-6 долоо хоног (1 хүн бүтэн цагаар)	6-12 долоо хоног (1 хүн бүтэн цагаар)	12 долоо хоногоос 6 сар хүртэлх (1 хүн бүтэн цагаар)	6-12 сар* (1 хүн бүтэн цагаар)
Эрүүл мэндэд үзүүлж болзошгүй нөлөөллийн талаар ерөнхий тоймыг тодорхойлдог.	Эрүүл мэндэд үзүүлж болзошгүй нөлөөллийн талаар илүү нарийвчилсан тоймыг тодорхойлдог.	Эрүүл мэндэд үзүүлж болзошгүй нөлөөллийг илүү нарийвчлан үнэлж, урьдчилан таамагласан тодорхой нөлөөллийн талаар илүү нарийвчилсан мэдээллийг өгдөг.	Эрүүл мэндэд учирч болзошгүй нөлөөллийг цогц үнэлдэг.
Цаг хугацаа, нөөц боломж хязгаарлагдмал үед хэрэглэхэд тохиромжтой.	Цаг хугацаа, нөөц боломж хязгаарлагдмал үед хэрэглэхэд тохиромжтой.	Цаг хугацаа, нөөц их шаарддаг.	Цаг хугацаа, нөөц их шаарддаг.
Бэлэн байгаа нотолгоо мэдээллийг цуглувулж, шинжилнэ.	Мэргэжилтнүүд болон гол оролцогч талуудын хязгаарлагдмал оролцоотойгоор бэлэн байгаа нотолгоо мэдээллийг цуглувулах, дүн шинжилгээ хийх үйл явц юм.	Бэлэн байгаа мэдээллийг цуглувулах, дүн шинжилгээ хийх, түүнчлэн оролцогч талууд болон гол мэдээлэгчдээс чанарын шинэ мэдээлэл цуглувулах явц юм.	Олон эх сурвалжаас шинээр мэдээлэл цуглувулах, дүн шинжилгээ хийнэ.
Үйл ажиллагаанууд нь бэлэн байгаа нөөцэд хандах, мэдээллийг нэгтгэх, үнэлэх зэрэг юм.	Үйл ажиллагаа нь нөөцэд тулгуурлах, уулзалт зохион байгуулах, дэмжих, мэдээллийг нэгтгэх, үнэлэх зэрэг орно. Нэмэлтээр тухайн чиглэлээр мэргэшсэн шинжээч, мэргэжилтний ажиллуулж болно.	Үйл ажиллагаа нь нөөцэд тулгуурлах, уулзалт зохион байгуулах, оролцогч талуудыг тодорхойлох, чанарын болон тоон мэдээлэл цуглувулах, дүн шинжилгээ хийх, мэдээллийг нэгтгэх, үнэлэх зэрэг орно. Нэмэлтээр тухайн чиглэлээр мэргэшсэн шинжээч, мэргэжилтний ажиллуулж болно.	Үйл ажиллагаа нь нөөцэд тулгуурлах, уулзалт зохион байгуулах, оролцогч талуудыг тодорхойлох, чанарын болон тоон мэдээлэл цуглувулах, дүн шинжилгээ хийх, мэдээллийг нэгтгэх, үнэлэх зэрэг орно. Нэмэлтээр тухайн чиглэлээр мэргэшсэн шинжээч, мэргэжилтний ажиллуулж болно.
НӨЛӨӨЛӨЛ БАГА		НӨЛӨӨЛӨЛ ИХ	
*Үнэлгээ хийх хугацаа нь үнэлгээний багийн гишүүдийн тооноос хамаарч өөр өөр байна. Жишээлбэл цогц үнэлгээний хувьд багийн 1 гишүүн бүрээр тооцоход үнэлгээ 12 сар үргэлжлэх ба 4 хүний бүрэлдэхүүнтэй баг 3 сарын хугацаанд хийнэ.			

4.2.7 Төслийн үйл ажиллагаанаас хүний эрүүл мэндэд үзүүлэх болзошгүй нөлөөллийг үнэлэхдээ өөрөө нөлөөллийг ач холбогдоор нь, сөрөг нөлөөллийг эрсдэлээр нь харгалзан эрэмбэлнэ.

Хүснэгт 4. Хүн амын эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн эрэмбэлэлт

Нөлөөллийн зэрэг	Нөлөөллийн цар хүрээ	Нөлөөллийн эрчим (Хүн амын дасан зохицох чадвар)	Үргэлжлэх хугацаа	Эрүүл мэндийн нөлөөлөл
Бага	Бага	Дасан зохицох чадвар бага зэрэг	Хязгаарлагдмал: сардаа 1-ээс цөөн	Эрүүл мэндэд нөлөөлөх эсэхийг тогтоох боломжгүй
Дунд	Хязгаарлагдмал	Өртсөн хүн ам дасан зохицох чадвартай	Богино хугацааны: 1 жилээс бага, цөөн давтамжтай	Хөнгөн хэлбэрийн өвчлөл үүснэ. Эмнэлгийн тусlamж, үйлчилгээ шаардлагагүй
Өндөр	Олон нийтийг хамарсан. Хязгаарлагдмал	Өртсөн хүн ам дасан зохицох чадвар сул	Дунд хугацааны: 1-6 жил, тасалдсан давтамжтай	Эрүүл мэндэд нөлөөлнө. Эмнэлгийн тусlamж авах шаардлагатай
Маш өндөр	Төслийн хамрах орон нутгийн хүрээнээс гарсан. Түгээмэл	Өртсөн хүн ам дасан зохицох чадваргүй, өвчлөл үүсгэнэ.	Урт хугацааны: Байнгын давтамжтай (амь насанд аюултай)	Амь насанд аюул учруулах эрдэлтэй, эмнэлгийн тусlamж, үйлчилгээ зайлшгүй шаардлагатай

Хүснэгт 5. Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний түвшин

Үнэлгээний түвшин ба нөлөөллийг үнэлэх			
Баримтад сууринласан	Түргэвчилсэн	Завсрын	Цогц
3-аас илүүгүй нөлөөллийг үнэлнэ.	3-аас илүүгүй нөлөөллийг илүү нарийвчлан үнэлнэ.	3-10 нөлөөллийг нарийвчлан үнэлнэ.	Бүх боломжит нөлөөллийг нарийвчлан үнэлнэ.
Эрүүл мэндэд үзүүлж болзошгүй нөлөөллийн талаар ерөнхий тоймыг тодорхойлдог.	Эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн талаар илүү нарийвчилсан тоймыг тодорхойлдог.	Эрүүл мэндэд үзүүлэх болзошгүй нөлөөллийн талаар илүү нарийвчилсан үнэлгээ өгч, урьдчилан таамагласан тодорхой нөлөөллийн талаар илүү дэлгэрэнгүй мэдээлэл өгдөг.	Эрүүл мэндэд учирч болзошгүй нөлөөллийн цогц үнэлгээ хийдэг.

4.2.8 Үнэлгээний хугацаа, төрөлд нийцүүлэн бэлэн байгаа нотлох баримт, баримт мэдээллийг нэмэлтээр цуглуулах хэрэгцээ, боломж зэргийг харгалзан үнэлгээнд ашиглах нотлох баримтын хүрээ, төрлийг тодорхойлно. Үүнд: Нотлох баримтыг цуглуулахад үндэсний суурь судалгааны мэдээлэлд тулгуурласан байна.

Хүснэгт 6. Нотлох баримт цуглуулах арга

ГОЛ АСУУДЛУУД	НОТОЛГООНЫ ЭХ СУРВАЛЖ			
	Олон нийтийн зөвлөл	Хэвлэлийн тойм	Бодлогын баримт бичгийн тойм	Шинэ мэдээлэл цуглуулалт
АШИГЛАЛТ- Төсөл хэрэгжсэний дараа тухайн газрыг хэн ашиглах вэ?	+++	++	+	++ (фокус бүлгийн, оролцогч талуудын ярилцлага)
НӨЛӨӨ- Төсөл нь эрүүл мэндийн тодорхойлогч хүчин зүйлийг өөрчлөх үү?	++	+++	+	++ (эрсдэлийн үнэлгээ)
ЯЛГААТАЙ НӨЛӨӨЛӨЛ- Төсөл нь ялгаатай нөлөө үзүүлэх үү?	+	+++	++	+++ (хүн ам зүйн дүн шинжилгээ)
АЧ ХОЛБОГДОЛ- Төслийн өөрчлөлт нь олон нийтэд/оролцогч талуудад чухал үү?	+++			+++ (фокус бүлгийн, оролцогч талуудын ярилцлага)
СЭТГЭЛ ХАНАМЖК- Орон нутгийн оршин суүгчид, үйлчилгээ үзүүлэгчид болон бусад оролцогч талууд төслийн өөрчлөлтөд сэтгэл хангалиун байна үү?	+++			+++ (фокус бүлгийн, оролцогч талуудын ярилцлага)
Бусад асуулт...				
Нэмэх тоо (+, ++, +++) нь тухайн асуултад хариулахын тулд тухайн нотлох баримтын эх сурвалжийг хэр хэмжээгээр ашиглахыг илэрхийлнэ.				

4.2.9 Болзошгүй нөлөөллийг тодорхойлох, зөвлөмж, шийдвэр гаргах, үнэлгээний төсөв, дагаж мөрдөх арга хэмжээ, оролцогч талуудтай хамтран ажиллах зэргийг тодорхой тусгасан үйл ажиллагааны календарчилсан төлөвлөгөө боловсруулна.

4.2.10 Цар хүрээг тодорхойлох үе шатны төгсгөлд үнэлгээний баг, бүрэлдэхүүний ажлын даалгавар, үнэлгээ хийх хугацаа, газар зүйн байршил, нөлөөлөлд өртөж болзошгүй хүн амын бүлэг, үнэлгээний түвшин, үйл ажиллагааны төлөвлөгөө зэргийг боловсруулсан байна.

4.3 Дүн шинжилгээ хийх

4.3.1 Нөлөөллийн зерэг, сөрөг байдал, нөлөөлөлд өртөх магадлалтай хүн амын эзлэх хувь ба ноцтой байдал, нөлөөллийн тохиолдох магадлал зэргийг харгалzan болзошгүй нөлөөлөлд дүн шинжилгээ хийнэ.

Хүснэгт 7. Эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл ба тэдгээрийн тайлбар

Магадлал	Шийдвэр нь давтамж, ноцтой байдал, хэмжээнээс үл хамааран эрүүл мэндийн тодорхойлогч хүчин зүйл эсвэл үр дунд нөлөөлөх итгэлтэй байдал
Боломжгүй	Тохиолдох боломжгүй нөлөө, нөлөөллийн механизмын эсрэг томоохон нотолгоотой байна.
Тодорхойлох боломж бага	Хязгаарлагдмал эсвэл тодорхой бус нотлох баримт бүхий логик үндэслэлтэй нөлөө
Магадлалтай	Тодорхойгүй байдал их, бодит, тогтвортой нотлох баримтууд бүхий логикийн хувьд үнэмшилтэй нөлөө

Маш их магадлалтай/тохио лдох нь тодорхой	Шалтгаан ба ерөнхий үр дагаврын нотолгоо хангалттай.
Ноцтой байдал	Болзошгүй нөлөөлөлд нь хүн амын эрүүл мэнд, сайн сайхан байдал, наслалтад нөлөөлөх байдал нь хэр зэрэг байх вэ?
Бага	Үйл ажиллагаа, сайн сайхан байдал, амьжиргаанд бага зэрэг нөлөөлөх ба үүнийг эрүүл мэндийн тогтолцооны чадавхын хүрээнд өөрчлөх боломжтой богино хугацааны цочмог нөлөө
Дунд	Эрүүл мэндийн тогтолцооны чадавхын хүрээнд зохицуулах боломжтой, үйл ажиллагаа, сайн сайхан байдал, амьжиргаанд ихээхэн нөлөөлдөг цочмог, архаг эсвэл байнгын нөлөө Эрүүл мэндийн тогтолцооны чадавхаар зохицуулагдах боломжгүй, үйл ажиллагаа, сайн сайхан байдал, амьжиргаанд үзүүлэх богино хугацааны цочмог нөлөө
Их	Эрүүл мэндийн тогтолцооны менежментээс үл хамааран хөдөлмөрийн чадвараа алдах эсвэл амь насанд аюул учруулж болзошгүй цочмог, архаг эсвэл байнгын нөлөө Хүүхдийн хөгжилд сөргөөр нөлөөлөх эсвэл ирээдүй хойч үедээ хор хөнөөл учруулах нөлөө
Цар хүрээ	Шийдвэр гаргалт нь эрүүл мэндэд хэрхэн нөлөөлөх вэ? (өөрөөр хэлбэл шинж тэмдгүүдийн давтамж, өвчин, осол гэмтэл, хөдөлмөрийн чадвар алдалт, нас баралтын тоонд ямар өөрчлөлт гарах вэ)?
Хязгаарлагдмал	Эрүүл мэндийн үр дагавар хүн амын <0.1% илрэх өөрчлөлт
Дунд зэрэг	Хүн амын эрүүл мэндийн үр дагаврын давтамж 0.1%-иас 1% хүртэлх өөрчлөлт
Их	Хүн амын эрүүл мэндийн үр дагаврын давтамж 1%-иас дээш өөрчлөлт
Тархалт	Эерэг, сөрөг үр дагавар нь хүн амын дунд жигд нөлөөлөх үү? Шийдвэр нь тэгш бус байдлыг багасгах боломжтой юу?
Шууд бус нөлөө	Шийдвэр нь хүн ам зүй, соёл, газар зүйн байршилаар тодорхойлогддог хүн амд харьцангуй сөрөг нөлөө үзүүлнэ.
Шууд бус ашиг тус	Шийдвэр нь хүн ам зүй, соёл, газар зүйн байршилаар тодорхойлогддог хүн амд пропорциональ бус ашигтай нөлөө үзүүлнэ.
Тэгш байдлыг дэмжих	Шийдвэр нь одоо байгаа эсвэл өмнөх үеийн эрүүл мэндтэй холбоотой тэгш бус байдал, эрүүл мэндийн ялгааг арилгана.

4.3.2 Нөлөөллийн талаарх нотолгоо нь шалтгаан, үр дагаврын хамаарлыг илэрхийлж байгаа эсэхийг хэвлэлийн тойм ашиглан үнэлнэ. Шаардлагатай бол орон нутагт судалгаа (асуумж, ярилцлага, фокус бүлэг, тархвар зүйн судалгаа) хийнэ.

4.3.3 Төслийн нөлөөлөлд өртөж болзошгүй орон нутгийн хүн амын онцлогийг тодорхойлно. Эрүүл мэндийг тодорхойлох хүчин зүйлүүд болон эрүүл мэндийн үр дүнгийн хэмжигдэхүүнийг тодорхойлж, эдгээр тодорхойлогч хүчин зүйлүүд болон үр дүнгийн талаарх бэлэн мэдээллийг нэгтгэн үнэлнэ.

4.3.4 Нөлөөллийг тоон байдлаар тооцох өгөгдөл байгаа эсэхийг тодорхойлж, тун хариу урвал, регрессийн тэгшигтгэл зэрэг тохиромжтой таамаглах загваруудыг ашиглан эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг тоон байдлаар тооцоолно.

4.3.5 Төслийн талаар гаргах шийдвэрийн хувилбар бүрийн хувьд эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн магадлал, ноцтой байдал, цар хүрээ, тархалтыг тодорхойлно.

**Хүснэгт 8. Эрүүл мэндийн нөлөөллийн үр дагавар, тохиолдох магадлалыг
үнэлэх шалгуур үзүүлэлт**

Ач холбогдлын түвшин	Шалгуур үзүүлэлт	
	Нөлөөллийн үр дагавар	Нөлөөлөл тохиолдох магадлал (доорх нөхцөлийн аль нэг нь бурдсан байх)
Нөлөөгүй (0)	Эрүүл мэндийн нөлөөгүй эсвэл зөвшөөрөгдхөх хэмжээнд	-
Бага (1)	<p>Эерэг нөлөө: Эрүүл мэнд, сайн сайхан байдал, амьдралын чанарт бага зэрэг зерэг нөлөөтэй.</p> <p>Сөрөг нөлөө: Эрүүл мэнд, сайн сайхан байдал, амьдралын чанарт үзүүлэх нөлөө бага.</p>	<ul style="list-style-type: none"> Өртөлтийн түвшин бага Өртөлт богино хугацаагаар үргэлжилдэг 100-аас цөөхөн хүнийг хамарсан Бага хэмжээний талбайг хамарсан
Дунд (2)	<p>Эерэг нөлөө: Сэтгэл зүйн сайн сайхан байдлыг илрэхий дэмжих, архаг суурь өвчиний эдгэрэлтэд эерэг нөлөөтэй.</p> <p>Сөрөг нөлөө: Архаг суурь өвчиний хүндруулэх, түр зуурын шинж тэмдэг үүсгэх, удаан хугацаанд сөргөөр нөлөөлөх</p>	<ul style="list-style-type: none"> Өртөлтийн түвшин дунд зэрэг Өртөлт дунд зэргийн хугацаагаар үргэлжилдэг 100-500 ажилтан болон мэдрэмтгий хүмүүсийг хамарсан
Өндөр (3)	<p>Эерэг нөлөө: Нас баралт, цочмог, архаг өвчлөл, сэтгэл санаанд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх</p> <p>Сөрөг нөлөө: Нас баралт, архаг, цочмог өвчин, сэтгэцийн эмгэгт хүргэх</p>	<ul style="list-style-type: none"> Өртөлтийн түвшин их Өртөлт удаан хугацаагаар үргэлжилдэг 500-аас олон ажилтан болон эмзэг бүлгийн хүмүүсийг хамарсан

Хүснэгт 9. Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний матрикс

Тохиолдох магадлал	Нөлөөллийн үр дагавар				
	Бага	Дунд	Их	Маш их	Ноцтой
Маш бага	Маш бага	Маш бага	Бага	Бага	Дунд
Бага	Маш бага	Бага	Бага	Дунд	Их
Дунд	Бага	Бага	Дунд	Их	Маш их
Их	Бага	Дунд	Их	Маш их	Ноцтой
Маш их	Дунд	Их	Маш их	Ноцтой	Ноцтой

4.3.6 Дүн шинжилгээний үе шатны төгсгөлд нөлөөлөлд өртөж болзошгүй хүн амын эрүүл мэндийн байдал, эрүүл мэндийн тодорхойлогч хүчин зүйлүүд, эмзэг байдал зэрэг суурь (одоо байгаа) нөхцөл байдлыг тодорхойлсон байна.

4.3.7 Төслийн талаар гаргах шийдвэрийн эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн шинж чанарыг тодорхойлсон байна.

4.4 Үнэлгээний үр дүнгийн менежмент хийх үе шат

- 4.4.1 Энэ үе шатанд үнэлгээний үйл явцыг баримтжуулан тайланд тусгах, үнэлгээний үр дүнгийн үнэн бодит байдлыг хянах, нээлттэй ил тод байдлаар хийгдсэн эсэхийг тодорхойлно.
- 4.4.2 Үнэлгээний үр дүн, зөвлөмжийг төсөл хэрэгжүүлэгч, шийдвэр гаргагч, орон нутгийн иргэд, холбогдох талуудад мэдээлэл харилцааны тохирох аргаар тайлагнаж, мэдээлнэ.
- 4.4.3 Болзошгүй сөрөг нөлөөллөөс сэргийлэх, бууруулах, зохицуулах, хэрэгжүүлэх арга зам болон эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг багтаасан нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулна.
- 4.4.4 Нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагааны төлөвлөгөө нь үнэлгээний үр дүн, санал зөвлөмж, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд холбогдох талуудын үүрэг, хариуцлагыг, эрсдэл тус бүрээр тодорхой тусгасан байна.
- 4.4.5 Нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд оролцогч талуудын санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхой тусгана.
- 4.4.6 Энэхүү төлөвлөгөөг байгаль орчны, нийгмийн болон бусад нөлөөллийн менежментийн төлөвлөгөө, яаралтай тусламжийн болон гамшигийн хариу арга хэмжээний төлөвлөгөөтэй уялдуулна.
- 4.4.7 Үр дүнгийн менежмент хийх үе шатны төгсгөлд үнэлгээний үр дүнгийн тайлан, нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулсан байна.

4.5 Төлөвлөгөөний хэрэгжилтийг хянах, үнэлэх үе шат

- 4.5.1 Үнэлгээний төгсгөлийн үе шатанд хүний эрүүл мэндэд учирч болох сөрөг нөлөөллийг бууруулах, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, зорилтот бүлэгт чиглэсэн нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хэрэгжилтийг хянах төлөвлөгөөг шинэчлэн сайжруулах үйл ажиллагааг хийнэ.
- 4.5.2 Нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагааны төлөвлөгөө болон зөвлөмжийн хэрэгжилтийг тухайн үнэлгээ хийсэн хуулийн этгээд төслийн үйл ажиллагааг эхэлснээс хойш үр дүнгийн үзүүлэлтийг 1 жилийн дараа, үр нөлөөний үзүүлэлтийг 3 жилийн дараа хянаж, үнэлнэ

ТАВ. ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- 5.1 Үнэлгээний тайлан нь дараах нийтлэг агуулгатай бичигдэнэ.
 - Үнэлгээний багийн мэдээлэл
 - Үнэлгээг гүйцэтгэгч байгууллагатай холбоо барих мэдээлэл
 - Багийн гишүүдийн мэргэжил, туршлагын мэдээлэл
 - Үнэлгээ хийхэд ашиг сонирхлын зөрчилтэй эсэх мэдэгдэл
 - Тайланг хянаж баталгаажуулагч талын нэр, эрх бүхий албан тушаалтны нэр

- Төслийн танилцуулга
 - Төслийн нэр, үйл ажиллагааны чиглэл
 - Төсөл хэрэгжүүлэгчийн нэр
 - Төслийн байршил
 - Төслийн хүрээнд хийгдэх дэд бүтэц байгуулалт, барилгажилтын танилцуулга
 - Төслийн ажиллах хүчиний тоо, суурьших хотхон
 - Төсөлд ашиглах байгалийн нөөц
 - Технологийн ерөнхий танилцуулга
 - Төсөл хэрэгжих хугацаа
- Үнэлгээний хураангуй дүн
- Үнэлгээний удиртгал
 - Үнэлгээ хийх үндэслэл
 - Зорилго
 - Үнэлгээний төрөл, түвшин
 - Үнэлгээний үе шат, зохион байгуулалтын товч мэдээлэл
- Үнэлгээ хийх мэдээ баримт цуглуванс арга зүй, эх сурвалж
- Үнэлгээний хүрээ
 - Оршин суугчдын эрүүл мэндэд нөлөөлөгч орчны болон зан үйлийн хүчин зүйлс, тэдгээрт өртөх хүн ам, гарах үр дагавар,
 - Эрүүл мэндийн чанар, хүртээмжид нөлөөлөгч хүчин зүйлс, тэдгээрт өртөх хүн амын бүлэг, гарах үр дагавар,
- Ашигласан баримтын эх сурвалж
 - Зохиогч, сэдэв, хэвлэлийн дугаар, огноо
- Хавсралт хүснэгтүүд

ЭРҮҮЛ МЭНДИЙН НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

Эрүүл мэндэд үзүүлэх цочмог нөлөөлөл: 21 хоног хүртэлх хугацаанд хөдөлмөрийн чадвараа түр алдах ба эмнэлгийн тусlamж авах шаардлага бүхий нөлөө.

Эрүүл мэндэд үзүүлэх архаг нөлөөлөл: Эрүүл мэндийн ноцтой байдал ба осол гэмтлийн улмаас 21 ба түүнээс дээш хоногийн хугацаанд хөдөлмөрийн чадвараа түр болон бүр мөсөн алдахад хүргэж буй эрүүл мэндэд үзүүлэх нөлөө.

Олон нийт: Үнэлгээ хийх гэж буй орон нутагт оршин суугчид бөгөөд тэдгээр нь төслийн нөлөөлөлд бие махбодын (жишээлбэл эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлэх эрсдэл, тав тухыг алдагдуулах гэх мэт) болон бие махбодын бус байдлаар (болзошгүй нөлөөллийн талаар санаа зовж байгаа хүмүүс) өртөж болзошгүй хувь хүн эсвэл бүлгүүд.

Өртөж болзошгүй хүн ам: Төслийн үйл ажиллагаатай холбоотой эрүүл мэндийн нөлөөлөлд өртөж болзошгүй хүмүүс

Орчны эрүүл мэнд: Хүний эрүүл мэндэд шууд болон шууд бусаар нөлөөлөх эсвэл нөлөөлж болзошгүй хүрээлэн буй орчны нөхцөл, аюулд чиглэдэг нийгмийн эрүүл мэндийн дэд хэсэг юм. Үүнд эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, гоо зүй, нийгэм, эдийн засгийн үнэт зүйлс, тав тухыг хангах, хүрээлэн буй орчны эерэг хүчин зүйлсийг дэмжих, физик, биологи, хими, цацрагийн болзошгүй аюулыг бууруулах замаар өвчин, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх зэрэг үйл ажиллагаа орно.

Орчны мониторинг: Агаар, ус, хөрс, хүнсэнд агуулагдах бодисын агууламжийг хянах.

Био мониторинг: Үйлдвэрлэл, үйлчилгээ, төслийн үйл ажиллагааны сөрөг нөлөөлөлд хүн амын хэрхэн өртсөнийг тодорхойлох зорилгоор тэдгээрийн биеэс авсан эд, эс, шингэнд химийн болон химийн бус хүчин зүйлсийн хуримтлалыг хэмжих арга

Өртөлтийн үнэлгээ: Нийт хүн ам, хүн амын янз бүрийн дэд бүлгүүд эсвэл хувь хүмүүсийн эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн цар хүрээ, давтамж, үргэлжлэх хугацаа, зам, цар хүрээний тоон болон чанарын үнэлгээ

Аюул: Тухайн хүчин зүйлийн эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд тодорхой төрлийн сөрөг нөлөө үзүүлэх чадвар

Эрүүл мэндийн үр дагавар: Аливаа үйл явдлын үр дагавар, эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн үр дүн бөгөөд эрүүл мэнд, сайн сайхан байдалд үзүүлэх нөлөөллийн цар хүрээг багтаана.

Эрүүл мэндийн асуудал: Төслийн нөлөөллийн улмаас хүрээлэн буй орчин, нийгэм, соёл, эдийн засаг зэрэг эрүүл мэндийн тодорхойлогч хүчин зүйлд үзүүлэх нөлөөллийн үр дүнд бий болсон эрүүл мэндэд нөлөөлж болзошгүй асуудлууд.

Эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээ: Тодорхой нөхцөл байдал, цаг хугацааны туршид хүн амын бүлэгт хими, биологи, физик, нийгмийн хүчин зүйлийн болзошгүй нөлөөллийг тооцоолох үйл явц

Эрсдэлийн менежмент: Сөрөг нөлөөллийг бууруулах, эерэг нөлөөллийг нэмэгдүүлэх зорилгоор боловсруулж хэрэгжүүлсэн үйл явц

Менежментийн шалгуурууд: Сөрөг нөлөөллийг хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд хүртэл бууруулах, эерэг нөлөөллийг нэмэгдүүлэх эрүүл мэндийн эрсдэлийн удирдлагын стратеги

Эрүүл мэндийн сайдын
2023 оны 09 дугаар сарын 29 өдрийн
4/550 дугаар тушаалын хавсралт

**Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний үйл ажиллагааны гүйцэтгэлийг
хянах загвар**

№	Үйл ажиллагаа	Гүйцэтгэл тийм ✓ үгүй ✗	Тайлбар
1. Нөхцөл байдлыг үнэлэх үе шат			
1.1	Төслийн талаарх тойм үзүүлэлтийг тодорхойлсон эсэх		
1.2	Шийдвэр гаргагч, төсөл хэрэгжүүлэгч, олон нийтийн төлөөлөлтэй хамтран ажилласан эсэх		
1.3	Эрүүл мэндэд үзүүлэх болзошгүй нөлөөлөл (эерэг, серөг)-ийг тодорхойлсон эсэх		
1.4	Шийдвэр гаргахад анхаарах гол асуудлыг тодорхойлсон эсэх		
1.5	Үнэлгээнд шаардлагатай нотолгооны бэлэн байдлыг тодорхойлсон эсэх		
1.6	Үнэлгээний санхүүгийн болон хүний нөөцийн хүртээмжтэй байдлыг судалсан эсэх		
1.7	Төсөл нь хүн амын эрүүл мэнд, сайн сайхан байдалд шууд байдлаар хэрхэн нөлөөлөхийг тооцсон эсэх		
1.8	Төсөл нь хүн амын эрүүл мэнд, сайн сайхан байдалд дам байдлаар хэрхэн нөлөөлөхийг тооцсон эсэх		
1.9	Төсөл нь эрүүл мэнд, боловсрол, нийгмийн халамжийн үйлчилгээний эрэлт хэрэгцээ, хүртээмж зэрэгт хэрхэн нөлөөлөхийг судалсан эсэх		
1.10	Үнэлгээ хийх шаардлагатай/шаардлагагүйг тодорхойлсон шийдвэр гарсан эсэх		
1.11	Болзошгүй нөлөөллийг багасгах талаарх мэдээллийг тусгасан зөвлөмж боловсруулсан эсэх		
2. Цар хүрээг тодорхойлох үе шат			
2.1	Үнэлгээний багийн ахлагч нь гишүүдийн ажил, үүргийн тодорхойлолтыг тодорхойлсон эсэх		
2.2	Үнэлгээ хийх газар зүйн байршлыг тодорхойлсон эсэх		
2.3	Үнэлгээ хийх хугацааг тодорхойлсон эсэх		
2.4	Болзошгүй нөлөөлөлд өртөх магадлалтай хүн амын эмзэг бүлгийг ангилан тодорхойлсон эсэх		
2.5	Эмзэг бүлгийн хүн амд үзүүлэх эерэг, сөрөг нөлөөлөл, түүний нөлөөлөх замыг тогтоосон эсэх		
2.6	Үнэлгээний түвшинг сонгоходоо багийн нөөц, хүчин чадал, төслийн хэмжигдэхүүн, болзошгүй нөлөөллийн хэмжээ зэргийг харгалzan үзсэн эсэх		
2.7	Болзошгүй нөлөөллийг үнэлэхдээ эерэг нөлөөллийг ач холбогдоор нь, сөрөг нөлөөллийг эрсдэлээр нь эрэмбэлсэн эсэх		
2.8	Нотлох баримт цуглуулах аргыг тодорхойлсон эсэх		

2.9	Болзошгүй нөлөөллийг үнэлэх талаар зөвлөмж, шийдвэр гаргасан эсэх		
2.10	Үнэлгээний төсвийг тодорхойлж, санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлсон эсэх		
2.11	Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулсан эсэх		
3. Дүн шинжилгээ хийх үе шат			
3.1	Нөлөөллийн тохиолдох магадлалыг тодорхойлсон эсэх		
3.2	Хүн амын эрүүл мэнд, сайн сайхан байдал, амьдралын хэв маягт үзүүлэх нөлөөллийн ноцтой байдлыг тодорхойлсон эсэх		
3.3	Нөлөөлөлтэй холбоотой эрүүл мэндийн үр дагаврын давтамж хэрхэн өөрчлөгдөх талаар тодорхойлсон эсэх		
3.4	Үнэлгээний шийдвэр болон үр дагавар нь хүн амын дунд хэрхэн нөлөөлөх талаарх тархалтыг тодорхойлсон эсэх		
3.5	Нөлөөллийн талаарх нотолгоо нь шалтгаан, үр дагаврын хамаарлыг илэрхийлж байгаа эсэхийг үнэлсэн эсэх		
3.6	Орон нутгийн нийгэм, эдийн засаг, хүн амын амьдралын хэв маяг зэрэг суурь нөхцөлийг судалсан эсэх		
3.7	Орон нутгийн хүн амын эрүүл мэндийг тодорхойлогч хүчин зүйлс, эрүүл мэндийн үр дүнгийн хэмжигдэхүүнийг тодорхойлж, үнэлсэн эсэх		
3.8	Болзошгүй нөлөөллийн эрүүл мэндэд үзүүлэх эрсдэлийг тоон байдлаар тооцоолсон эсэх		
3.9	Болзошгүй нөлөөллийн тохиолдох магадлал, үр дагаврыг тодорхойлж, матрикс аргаар эрсдэлийг үнэлсэн эсэх		
4. Үнэлгээний үр дүнгийн менежмент хийх үе шат			
4.1	үнэлгээний үр дүнгийн үнэн бодит байдлыг хянах, нээлттэй ил тод байдлаар хийгдсэн эсэхийг баталгаажуулсан эсэх		
4.2	Үнэлгээний үр дүн, зөвлөмжийг төсөл хэрэгжүүлэгчид мэдээлсэн эсэх		
4.3	Нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд нөлөөллийг бууруулах үйл ажиллагааг тодорхой тусгасан эсэх		
4.4	Нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд зорилтот бүлгийн хүн амыг тусгасан эсэх		
4.5	Нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд үр дүнгийн үзүүлэлтийг тусгасан эсэх		
4.6	Нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд үр нөлөөний үзүүлэлтийг тусгасан эсэх		
4.7	Үнэлгээний үр дүнг шийдвэр гаргагчдад тайлгасан эсэх		
4.8	Үнэлгээний үр дүнг орон нутгийн иргэд, холбогдох талуудад мэдээлсэн эсэх		
5. Төлөвлөгөөний хэрэгжилтийг хянах, үнэлэх үе шат			
5.1	Нөлөөллийг бууруулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх аргыг тодорхойлсон эсэх		
5.2	Нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагааны хэрэгжилтийг хэрхэн үнэлэх талаар тодорхойлсон эсэх		